

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ

Технологи, бодлого, стратеги, дэмжих тогтолцоо

Израиль улсад болох мэргэжлийн сургалт-аяллын танилцуулга

Израиль орны түршлага



Израиль улс нь Газар дундын тэнгисийн эрэгт байдаг. Газар нутгийн хагас нь хуурай, хагас хуурай шинжтэй хэдий ч орчин үеийн өндөр технологийн тусламжтайгаар сүүлийн хэдэн арван жилд газар тариалангийн салбарыг эрчимтэй хөгжүүлж чаджээ.

Израиль нь дуслын усалгааны техник, технологийн нээлтээрээ дэлхийд алдаршсан орон бөгөөд хөдөө аж ахуйн салбарт ус хэмнэлтийн бусад олон технологи ашиглаж байна. Тухайлбал тус орон нь хаягдал усыг дахин боловсруулах тал дээр дэлхийд тэргүүлж байгаа бөгөөд нийт хаягдал усныхаа 80 гаруй хувийг дахин боловсруулж газар тариалангийн усалгаа болон үйлдвэрлэлийн бусад зориулалтаар хэрэглэж байна.

Түүний зэрэгцээ, Израйлийн хөдөө аж ахуйн салбар нь бүхэлдээ дэвшилтэт технологид тулгуурласан эрчимжүүлсэн үйлдвэрлэлийн тогтолцоотой. Үрийн чанар болон төрөл зүйлийг олон болгох нээлтүүд болон хүлэмжийн буюу ургамлын сувилахуйн хөгжил нь бүтээмжийг нэмэгдүүлэхэд ихээхэн түлхэц болж байна. Тус улсын засгийн газар нь туршилт судалгааны аж ахуй буюу газар тариалангийн судалгаа хийгдэж байгаа газар нутгийг онцгойлон анхаардаг.

Энэхүү мэргэжлийн сургалт-аялал нь Израиль улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжилд хүргэсэн шийдлүүдийг газар дээрээс нь үзэж, туршлага судлахад чиглэгдсэн. Оролцогчид нь шинэ техник, технологитой танилцахаас гадна орон нутгийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үндэсний бодлого, хөгжлийн үйл явцад орон нутгийн хөрөнгийг хэрхэн зохистой хэрэглэх талаар суралцана.

Сургалтын агуулга

Долоо хоногийн энэхүү мэргэжлийн сургалт-аялал нь Израйлийн газар тариалангийн салбарт гарсан ололт амжилтын туршлагад тулгуурлан явагдана. Энэ сургалт-аялалын үр дүнд оролцогчид дараах мэдлэг, чадварыг эзэмшинэ:

- Газар тариаланг эрчимтэй хөгжүүлсэн технологийн нээлтүүд
- Усалгааны тогтолцоо, тоног төхөөрөмж, менежментийн дэмжлэг
- Газар тариалангийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тогтолцоо
- Үр ашгийн нэмэгдүүлэх, орлогын эх үүсвэр бий болгох
- Хөдөө орон нутгийн хөгжүүлэх уламжлалт тогтолцоо

Хөтөлбөр



Оролцогчид газар тариалангийн аж ахуй, үйлдвэрлэлтэй газар дээр нь очиж танилцахаас гадна засгийн газрын болон орон нутгийн удирдлагууд, олон нийтийн болон хувийн хэвшлийн төлөөлөлтэй уулзаж ярилцаж тэдний туршлагаас хуваалцана. Хэрэгжиж буй төслүүдтэй газар дээр нь танилцаж, нэвтрүүлэх боломжтой туршлагыг эх үүсвэрээс нь шууд суралцах боломжийг оролцогчдод олгоно.

Энэхүү урьдчилсан хөтөлбөр нь оролцогчдын хэрэгцээ шаардлагаас хамааран харилцан тохиролцож өөрчлөгдөх боломжтой.

Израйльд тогтмол болдог газар тариалангийн чиглэлийн олон улсын үзэсгэлэнгийн үеэр тус сургалтын цаг хугацааг зохицуулж болно.

Хэн оролцож болох вэ?

Энэхүү мэргэжлийн сургалт-аялалд хөдөөгийн хөгжил, байгаль орчин, хөдөө аж ахуй, газар тариалан, нөөцийн менежмент, төлөвлөлт, эдийн засгийн чиглэлийн төр засгийн байгууллага, яамдын бодлого боловсруулж, шийдвэр гаргах түвшний албан тушаалтан болон дээрх чиглэлийн орон нутгийн төр захиргааны байгууллагын ажиллагсад, олон нийтийн байгууллага болон хувийн хэвшлийн төлөөлөл, сонирхогчид оролцоно.

Түүх, дурсгалын аялал

Израйль нь жүүд, христос, лалын шашны сүм хийд, дурсгалт газруудаар баялаг орон. Мэргэжлийн сургалт-аялалын үер оролцогчид нь Ирусалем хотын эртний дурсгалт газрууд болон Галилей нуурын эргэн тойрны үзэсгэлэнт байгаль, Сөнөсөн тэнгисээр аялна.

Мэргэжлийн сургалт-аяллын бүрэлдэхүүнд багтах зүйлс:

- Туршлага судлах мэргэжлийн сургалт-аялалууд, мэргэжлийн уулзалтууд
- Нисэх онгоцны буудлаас угтах, үдэх унааны үйлчилгээ
- Орон нутагт зорчих болон дурсгалт газруудад нэвтрэх эрх
- Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчийн үйлчилгээ
- Израйльд байх хугацааны эрүүл мэндийн даатгал
- Өглөө, үдийн хоол
- Зочид буудлын зардал
- Ирусалем болон Назарет хотын аялал

Энэхүү урьдчилсан хөтөлбөр болон сургалт-аялалтай холбоотой нэмэлт мэдээлэл авч, санал хүсэлтээ солилцох бол дараах хаягаар харилцана уу.

Зохион байгуулагч:

Weitz Center for Sustainable Development, Israel
Ногоон гариг - Ногоон ирээдүй ТББ, Улаанбаатар

Холбоо барих:

Монголд: Н.Оюундарь: earthgreen.ngo@gmail.com Утас: 95052526

Израйльд: Ms. Adi Dishon: adi@weitz-center.org Telephone: 972-8-9474111; Cellular: 972-50-4217616